

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ.....	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ
НЭГЖИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ц.ТҮМЭНБАЯР ТАНАА

2020.02.21 № 06/564
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ц.Түмэнбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Улсын комиссын 10/07/19 дугаар шийдвэрийн дагуу 2019 оны 7 дугаар сарын 03-нд “Улаанбаатар-Хөшигийн хөндий олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам”, 10/10/19 дугаар шийдвэрийн дагуу 8 дугаар сарын 06-нд “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам”, 10/11/19 дугаар шийдвэрийн дагуу 8 дугаар сарын 08-нд “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам”-ыг тус тус хөрөнгийг хүлээн авч, “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26 дугаар зүйлийн 26.1.1-д “гэрээ, хэлэлцээрт заасан төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж, ажлууд бүрэн хэрэгжсэн” гэж заасны дагуу төслийн үйл ажиллагаа дуусвар болж байгаатай холбогдуулан тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөж, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторов туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа нь төслийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлэх зорилготой.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь дараах төслүүдийг дээрх зорилгын хүрээнд хариуцан ажилладаг. Үүнд:

- “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төсөл;
- “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам барих” төсөл;
- “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам барих” төсөл.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус нэгжийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous 3.0 программ хангамж ашигладаг байна.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 452,541.0 мянган төгрөгөөс тооцон 9,050.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшний тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,211,227.02 мянган төгрөгөөр буюу 30.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(мянган төгрөг)
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	153,474.3	0.0	(153,474.3)
Авлага	11,620.1	76,554.1	64,934.0
Урьдчилгаа	7,979,610.8	0.0	(7,979,610.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	474,966,796.0	627,245,134.2	152,278,338.2
Нийт хөрөнгө	483,111,501.4	627,322,728.4	144,211,227.0
Өр төлбөр	22,514,958.5	21,128,217.3	(1,386,741.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	460,596,542.8	606,194,511.1	145,597,968.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	483,111,501.4	627,322,728.4	144,211,227.0

Мөнгөн хөрөнгө

Тайлант хугацаанд бусад орлого 373,177.1 мянган төгрөгөөр, арилжааны банкны харилцахын хүү 1,297.0 мянган төгрөгөөр, гадаад валютын ханшийн зөрүүний олз 1,156.2 мянган төгрөгөөр, нийт 375,630.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин төслийн нэгжийн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгийн зардал 452,550.7 мянган төгрөг, төвлөрүүлэн шилжүүлэг 76,554.1 мянган төгрөг, нийт 529,104.6 мянган төгрөгийн мөнгөн зарлага гарч жилийн эцэст үлдэгдэлгүй болсон байна.

Авлага

“Нар-Урт” ХХК-аас оффисын түрээсийн нэг сарын барьцааны авлага 10,580.1 мянган төгрөг, “Юнивишн” ХХК-аас интернет, суурин утасны барьцаа 1,040.0 мянган төгрөг, нийт 11,620.1 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд улсын төсөвт 76,554.1 мянган төгрөг төвлөрүүлсэнтэй холбоотойгоор татаас, санхүүжилтийн авлага үүссэн байна. Төслийн үйл ажиллагаа дуусч байгаатай холбогдуулан ажлын байрны түрээсийн гэрээг цуцалж, барьцааны авлагыг суутгаж, жилийн эцэст 76,554.1 мянган төгрөг болжээ.

Урьдчилгаа

“Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам барих” төслийн урьдчилж гарсан зардал 7,979,610.8 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант жилд зам, барилгын ажил дууссантай холбоотойгоор 7,979,610.8 мянган төгрөгийн урьдчилгааг бусад эргэлтийн хөрөнгөнд шилжүүлж үлдэгдэлгүй болсон байна.

Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө 474,966,796.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд зам, барилгын ажил дууссантай холбоотойгоор “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төслийн барилгад 80,453,400.8 мянган төгрөг, “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төслийн зөвлөхөд 2,193,687.1 мянган төгрөг, “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам барих” төсөлд 53,756,998.8 мянган төгрөг, “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам барих” төсөлд 15,874,251.3 мянган төгрөг, нийт 152,278,338.2 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл нэмэгдэж, 627,245,134.2 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй болжээ.

Өр төлбөр

Ажилчидтай холбоотой өглөг 2,400.9 мянган төгрөг, барилгын ажлын гэрээний дагуу чанарын баталгааны 5 хувийн суутгал буюу байгууллагад төлөх өглөг 22,512,557.6 мянган төгрөг, нийт 22,514,958.5 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант жилд барьцаа 7,457,517.7 мянган төгрөг шинээр үүсчээ. Харин ажилчидтай холбоотой өглөг 2,400.9 мянган төгрөг, зам, барилгын ажил дууссантай холбоотойгоор “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төслийн 8,841,858.0 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж эцсийн үлдэгдэл нь 21,128,217.3 мянган төгрөг болсон байна.

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/

Тайлант үеийн үр дүн 145,597,968.3 мянган төгрөгөөр нэмэгджээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төсөл, “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам барих” төсөл болон “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам барих” төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан тайлант онд 78,039,202.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,801,862.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 74,237,340.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тус тус баталжээ.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрийн хураамж буюу урсгал зардал 3,801,862.2 мянган төгрөг батлагдсанаас 3,778,633.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Харин барилга байгууламж буюу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 74,237,340.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гадаад эх үүсвэрээс гүйцэтгэлээр 88,645,934.2 мянган төгрөг, “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төслийн хүрээнд өмнөх жилийн гүйцэтгэл тайлант жилд орсонтой холбогдуулан 53,745,238.5 мянган төгрөгийг төсвийн тохируулга хийж төсвийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 92,424,568.2 мянган төгрөг буюу 116 хувьтай байгаа нь “Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам барих” төсөл, “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам барих” төсөл болон “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам барих” төслийн ажил 2019 онд дуусаж, үлдэгдэл санхүүжилт хийгдсэнтэй холбоотой байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан **“Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”**-ын 26.1.1, 26.1.2, 26.2-т заасны дагуу төслийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн дүгнэлт, төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлсэн байдал, ажлын гүйцэтгэлд анхаарах шаардлагатай байна.

2.12. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв, гүйцэтгэлийн 8, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 нийт 19 төрлийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

“Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.1.1-д “гэрээ, хэлэлцээрт заасан төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж, ажлууд бүрэн хэрэгжсэн” гэж заасны дагуу төслийн үйл ажиллагаа дуусвар болж байгаатай холбогдуулан менежментийн захидал өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	483,111,501,400.02	627,322,728,421.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	153,474,381.17	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	153,474,381.17	0.00
31210	Төгрөг	32,366,430.83	0.00
31211	Төрийн сангийн харилцах	32,366,430.83	0.00
31220	Гадаад валют	121,107,950.34	0.00
31223	Арилжааны банк дахь харилцах	121,107,950.34	0.00
33	АВЛАГА	11,620,150.00	77,594,166.04
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	76,554,166.04
33500	Бусад авлага	11,620,150.00	1,040,000.00
33510	Байгууллагаас авах авлага	11,620,150.00	1,040,000.00
34	УРЬДЧИЛГАА	7,979,610,817.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	7,979,610,817.00	0.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	474,966,796,051.85	627,245,134,255.02
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	474,966,796,051.85	627,245,134,255.02
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	483,111,501,400.02	627,322,728,421.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,514,958,587.93	21,128,217,302.68
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,514,958,587.93	21,128,217,302.68
41300	Өглөг	22,514,958,587.93	21,128,217,302.68
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,400,909.82	0.00
41360	Бусад өглөг	22,512,557,678.11	21,128,217,302.68
41361	Байгууллагад төлөх өглөг	22,512,557,678.11	21,128,217,302.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,596,542,812.09	606,194,511,118.38
51	Засгийн газрын хувь оролцоо	460,596,542,812.09	606,194,511,118.38
51200	Хуримтлагдсан үр дүн	460,596,542,812.09	606,194,511,118.38
51210	Өмнөх үеийн үр дүн	268,677,989,669.80	460,596,542,812.09
51220	Тайлант үеийн үр дүн	191,918,553,142.29	145,597,968,306.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	483,111,501,400.02	627,322,728,421.06

4.2. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	191,918,553,142.29	146,169,806,816.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,918,553,142.29	146,169,806,816.85
120	Нийтлэг татварын бус орлого	191,918,553,142.29	146,169,806,816.85
120002	Хүүгийн орлого	15,111,911.17	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,903,441,231.12	146,169,806,816.85
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	191,903,441,231.12	146,169,806,816.85
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	191,918,553,142.29	146,169,806,816.85
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	571,838,510.56
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	571,838,510.56
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	191,918,553,142.29	145,597,968,306.29

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	191,918,553,142.29	146,697,755,454.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	191,918,553,142.29	146,697,755,454.59
120	Нийтлэг татварын бус орлого	191,918,553,142.29	146,697,755,454.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,903,441,231.12	146,697,755,454.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,297,072.21
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	191,903,441,231.12	146,169,806,816.85
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	0.00	153,474,381.17
120009	Бусад орлого	0.00	373,177,184.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,038,386,954.40	4,307,738,896.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,038,386,954.40	4,307,738,896.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,038,386,954.40	4,231,184,730.81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,038,386,954.40	4,231,184,730.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,038,386,954.40	4,231,184,730.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	76,554,166.04
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	76,554,166.04
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	76,554,166.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	76,554,166.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	181,880,166,187.89	142,390,016,557.74
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	181,902,184,855.83	142,391,172,844.51
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	181,902,184,855.83	142,391,172,844.51
2200	Дотоод эх үүсвэрээр	181,902,184,855.83	142,391,172,844.51
220001	Барилга байгууламж	181,902,184,855.83	142,391,172,844.51
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-181,902,184,855.83	-142,391,172,844.51
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	1,156,286.77
14	Бусад эх үүсвэр	0.00	1,156,286.77
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	1,156,286.77
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-22,018,667.94	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	175,493,049.11	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	153,474,381.17	0.00

4.4. Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			-	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт			0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг			0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн			0.00	0.00
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			460,596,542,812.09	460,596,542,812.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			460,596,542,812.09	460,596,542,812.09
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт			0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг			0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн			145,597,968,306.29	145,597,968,306.29
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			606,194,511,118.38	606,194,511,118.38

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,039,202,200.00	92,424,568,260.32	-14,385,366,060.32	118.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,801,862,200.00	3,778,633,972.34	23,228,227.66	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,801,862,200.00	3,778,633,972.34	23,228,227.66	99.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,801,862,200.00	3,778,633,972.34	23,228,227.66	99.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,801,862,200.00	3,778,633,972.34	23,228,227.66	99.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	74,237,340,000.00	88,645,934,287.98	-14,408,594,287.98	119.0
220001	Барилга байгууламж	74,237,340,000.00	88,645,934,287.98	-14,408,594,287.98	119.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,039,202,200.00	92,799,042,516.89	-14,759,840,316.89	119.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	78,039,202,200.00	92,799,042,516.89	-14,759,840,316.89	119.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,297,072.21	-1,297,072.21	0.0
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	78,039,202,200.00	92,424,568,260.32	-14,385,366,060.32	118.0

